

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2015 оны 1/152 дот албан бичгийн хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН 2015 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тус газар нь авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г баталж, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс болон бусад нэгжүүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2015 онд авлигын эсрэг үйл ажиллагаанд "Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт", "Авлигатай тэмцэх санал санаачилга" гэсэн 2 үндсэн чиглэлээр 20 зорилтын хүрээнд 62 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Авлигын эсрэг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг төлөвлөгөөнд заасан зорилтын хүрээнд багцлан гаргав.

**Нэг. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг хангах хүрээнд:**

Үйл ажиллагааны зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, холбогдох мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах;

Байгууллагын нийт албан хаагчдын хурал, удирдах ажилтны зөвлөгөөн, газар, хэлтсийн хурал, сургалт, семинар дээр ерөнхий газрын дарга, газар, хэлтсийн удирдлагууд авлигаас урьдчилан сэргийлэх талаар тогтмол мэдээлэл хийж, улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хүргэх, үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах, үйлчилгээний шат дамжлагыг бууруулах санал санаачилга гарган ажиллаж байна.

Тус газрын албан ёсны цахим хуудас <https://burtgel.gov.mn> болон мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах буланг ажиллуулж, мэдээллийг тогтмол шинэчилж хэвшсэн. Уг ажлын хүрээнд иргэд тус газрын үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх бүх мэдээллийг энгийн ойлгомжтой, хүртээмжтэй шуурхай байдлаар хүргэх, зайлшгүй шаардлагатай үйлчилгээний баримт бичгийн бүрдүүлэлтийн жагсаалт, маягыг татаж авах, хайлт хийх зэрэг хэрэгтэй мэдээллээ энгийн хялбар аргаар үзэх, ашиглах боломжийг бий болгож өгсөн.

Тайлангийн хугацаанд байгууллагын цахим хуудасны "Авлигын эсрэг үйл ажиллагаа" буланд Авлигын эсрэг хууль, Авлигын мөн чанар, шалтгаан, хор хөнөөлийн талаарх сургалтын материал, 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан, УБЕГ-ын 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигын эсрэг үйл ажиллагааны 2015 оны эхний хагас жилийн тайлан, Авлигын эсрэг олон улсын өдрийн талаарх мэдээлэл, ярилцлага, авлига, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээ зэрэг мэдээллийг шинэчлэн байршуулав.

Тус газарт Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн "Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээн таниулах ажлын гарын авлага", "Нийтийн албан

тушаалтнуудад зориулсан гарын авлага”, “Шударга ёс” сэтгүүлийн 2014 оны 01, 02 дугаар, “Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан нарт зориулсан гарын авлага”-ыг тус тус нийслэлийн Улсын бүртгэлийн газар, 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс болон холбогдох газар, хэлтсийн албан хаагчдад танилцуулж, хүргүүлэв. Мөн АТГ-аас бэлтгэн ирүүлсэн брошур, сурталчилгааны материалыг 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн Бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний заал танхимуудад байршуулж, иргэдэд тараах ажлыг зохион байгуулж ажиллав.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, үйлчилгээ, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчилан таниулах үүднээс иргэдэд зориулсан мэдээлэл өгөх ажлыг сард тогтмол 1 өдөр зохион байгуулж хэвшээд байна. Арга хэмжээний үеэр иргэдэд иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн бүртгэлийн болон иргэний бүртгэлийн архивын лавлагаа, бүртгэлийн анхан шатны мэдээлэл, бүрдүүлэх материалын гарын авлага, товхимол зэргийг тарааж, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг амаар болон бичгээр хүлээн авч, зохих журмын дагуу шийдвэрлэн ажиллаж байна.

*Үйл ажиллагааны зорилт 2. Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох;*

Улсын бүртгэлийн эрх зүйн орчинг сайжруулах хүрээнд Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 2014 онд Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийг Засгийн газраас 2015 онд УИХ-д өргөн мэдүүлж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг хийгдээд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Шинэчлэн найруулсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөл, Иргэний бүртгэлийн тухай хуулийн төсөл, УИХ-ын нэгдсэн чуулганаар 2015 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг байгууллагын <https://burtgel.gov.mn> цахим хуудсны “Хэлэлцүүлэг” буланд байршуулж, хуулийн төсөлд иргэд олон нийтийн ирүүлсэн саналыг тусган ажилласан.

ГХГЗЗГ-т Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг хүргүүлж, тус газрын саналыг авч, хуулийн төсөлд тусгасан.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтээр хэлэлцүүлэхээр байгууллагын цахим хуудаст нийт 8 удаа зар байршуулан ажилласан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аас 2015 оны 1 дүгээр сарын 29-ны өдөр баталсантай холбогдуулан Хууль зүйн сайдын 2015 оны А/39, А/40, А/41, А/42 тоот тушаалаар батлагдан гарсан “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”, “Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам”, “Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих журам”, “Хуулийн этгээдийн нэр олгох журам”-ын төсөл болон УБЕГ-ын даргын 2015 оны 334 дүгээр тушаалаар

батлагдсан "Маягт, индекс, баталгааны тэмдгийн загварыг шинэчлэн батлах тухай", 335 дугаар тушаалаар батлагдсан "Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын төслийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, ТББ, иргэд олон нийтийн саналыг авч, төсөлд тусган ажилласан.

*Үйл ажиллагааны зорилт:3. Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах;*

Тус байгууллагын дотоод үйл ажиллагаанд хийх аудит, бүртгэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг <https://burtgel.gov.mn> цахим хуудсанд байршуулан ажиллаж байна. Үүнд: "Дотоод аудитын хэлтсийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө", "Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2015 онд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө", "Улсын бүртгэлийн ерөнхий газрын эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн менежментийн 2015 оны төлөвлөгөө"-г тус тус байгууллагын цахим хуудаст байршуулж, олон нийтэд мэдээлж байна.

2015 онд Өмнөговь, Орхон, Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2014 он, 2015 оны эхний улирлын санхүүгийн үйл ажиллагаанд, дотоод аудитыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн. Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийж, холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудасны "Үйлчлүүлэгч танд" булангийн Тайлан хэсэгт байршуулав. Мөн буланд Дотоод аудитын хэлтсийн 2015 оны үйл ажиллагааны талаарх товч мэдээлэл, Дотоод аудитын хэлтсээс хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, холбогдох нэгжүүдэд өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлтийн хяналтын хүснэгт зэрэг мэдээллийг байршуулав.

Улсын бүртгэлийн төв архивын газрын Иргэний баримтын архивын цахимжуулалтын үйл ажиллагаа, Эд хөрөнгийн бүртгэл, цахимжуулалтын газрын үйл ажиллагаанд тус тус төлөвлөгөөт бус дотоод аудит хийгдэж, аудитын мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулсан.

Мөн Архангай, Булган, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Хөвсгөл аймгийн бүртгэлийн хэлтэс, нийслэлийн Багануур, Налайх дүүргийн бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт, нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Багахангай дүүргийн Бүртгэлийн хэлтэс /иргэн, эд хөрөнгийн эрхийн бүртгэл/-ийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг явуулж, дүнг байгууллагын цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.

Шалгалтын дүнтэй холбогдуулан илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг шалгалт явуулсан бүртгэлийн хэлтсүүдэд хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Бүртгэлийн хяналтын чиглэлээр хийж гүйцэтгэсэн статистик тоон мэдээг сар бүр байгууллагын цахим хуудсанд байршуулж байна.

*Үйл ажиллагааны зорилт:4. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх;*

Хуульд заасны дагуу байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудсанд төсөв санхүүтэй холбоотой мэдээ мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна. Энэ хүрээнд

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2015 оны батлагдсан төсөв, тодотголоор батлагдсан төсвийг 2015 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, 2014 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг 04 дүгээр сарын 01-ний өдөр Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан.

Мөн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2014 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн 2014 оны аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байршуулсан.

Улсын бүртгэлийн үйлчилгээний орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сар бүр Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтийг 14 хоногийн дотор Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн.

Мөн Төсвийн байгууллагын санхүүжилтийн 2015 оны 01-10 сарын мэдээ, 2015 оны улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа, 2016 оны урсгал төсвийн төсөл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2015 оны худалдан авах ажиллагааны ил тод байдлын мэдээлэл зэрэг мэдээллийг байгууллагын цахим хуудасны “Мэдээллийн ил тод байдал” булангийн Санхүүгийн ил тод байдал хэсэгт байршуулан ажиллаж байна.

2014, 2015 оны хагас жилийн байдлаар тус газарт гадаадын зээл, тусламжаар төсөл хэрэгжээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, орон нутгийн улсын бүртгэлийн байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагааг долоо хоног бүрийн баасан гаригт шалгаж, илтгэх хуудсаар танилцан ажиллаж байна.

*Үйл ажиллагааны зорилт:5. Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах;*

Улсын бүртгэлийн байгууллагаас үзүүлж буй Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ болон Улсын бүртгэлийн төв архивын үйлчилгээ, бүртгэлийн хяналт, гадаадын иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн үйлчилгээний төрөл, бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд бүрдүүлэх баримт бичгийн талаарх мэдээлэл болон холбогдох бусад мэдээллийг <https://burtgel.gov.mn> цахим хуудасны “Үйлчилгээ” буланд байршуулж, мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.

Мөн цахим хуудасны “Хууль эрх зүй” буланд Иргэний улсын бүртгэл хөтлөх журам, Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам, Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам, Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам, Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам, Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам, Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам, Иргэний овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчлөх журам, Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал, Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлал, Монгол улсын иргэний харъяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бичиг баримтын жагсаалт, түүнийг бүрдүүлэх журам, Монгол улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газраас үндэсний энгийн гадаад паспорт

олгох, хугацаа сунгах, хүчингүй болгох, бүртгэл хөтлөх тухай заавар, Төрсний бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, бүртгэл хөтлөх журам, Иргэний бүртгэл, мэдээллийн байгууллагаас үндэсний энгийн гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох технологи ажиллагааны журам, Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах журам, Монгол улсын иргэний үнэмлэх олгох, түүнд мэдээлэл оруулах, бүртгэл хөтлөх журам, Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд болон эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэлд бүртгэх тусгай журам, Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх журам, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем (ePRS)-д хөтлөх журам, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам, Барьцааны эд хөрөнгөтэй холбоотой эрхийн улсын бүртгэлийн лавлагаа, мэдээллийг банкинд цахим хаягаар олгох журам, Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам зэрэг дүрэм, журам, зааврыг байгууллагын цахим хуудасны “Хууль, эрх зүй” буланд байршуулж, мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжийн хэрэгжилт бусад цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд, олон нийтэд цаг тухайд нь хүргэж, сурталчилан ажиллав.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжээс хүргэж эхэлсэн талаар болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, хуулийн этгээдийн онлайн үйлчилгээ, бусад цаг үе, үйл явдлын арга хэмжээг сурталчилах хүрээнд тайлант хугацаанд нийт 47 хэвлэл мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор 122 удаагийн сурталчилгааг телевиз, мэдээллийн цахим сайт, өдөр тутмын сониноор дамжуулан олон нийтэд хүргэхээс гадна телевиз, радиогийн нийт 17 нэвтрүүлэгт оролцсон.

*Үйл ажиллагааны зорилт:6. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах;*

Байгууллагын хүний нөөцийн ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд байгууллагын <https://burtgel.gov.mn> цахим хуудсанд тусгай цонхыг нээн ажиллуулж, УБЕГ-ын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж үнэлэх журам, Төрийн албаны салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, үнэлгээ, хуралдааны шийдвэр, Ёс зүйн хорооны талаарх мэдээ мэдээллүүдээс гадна сул орон тооны ажлын зар зэрэг хүний нөөцтэй холбоотой нийт 111 мэдээ мэдээлэл болон албан хаагчдад сахилгын шийтгэл оногдуулсан ерөнхий газрын даргын 78 тушаалыг байршуулсан байна.

Мөн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл, төрийн албаны хууль тогтоомж, дүрэм журмыг тоймлон байршуулж байна.

Булган аймгийн Тэшиг сумын улсын бүртгэгчийн болон Архангай, Завхан, Увс, Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт явуулах зарыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт ил байршуулан зарлаж сонгон шалгаруулалтыг явуулсан.

Үйл ажиллагааны зорилт:7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах;

Байгууллагын 2015 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын <https://burtgel.gov.mn> цахим хуудас, мэдээллийн самбар, худалдан авах ажиллагааны нэгдсэн цахим хуудас, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тус тус байршуулан ажиллаж байна.

Хууль зүйн сайдын баталсан 2015 оны урсгал зардлаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2015 оны худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, нээлттэй 3, хязгаарлагдмал 2 тендер зарлаж, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор урилгыг өдөр тутмын "Өдрийн сонин" болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, худалдан авах ажиллагааны нэгдсэн цахим хуудас, шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар олон нийтэд зарлаж, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтын журмыг байршуулж, олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Хязгаарлагдмал тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим хуудсанд тухай бүр мэдээлж ажиллав.

Байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тус газраас 2015 онд зарласан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд "Худалдан авах ажиллагааны түншлэл", "Сургалт арга зүйн зөвлөгөө өгөх төв" Төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан.

Үйл ажиллагааны зорилт:8. Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох;

Албан хаагч нэг бүрийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг шинэчлэн батлахаар төлөвлөгөөнд тусгасны дагуу, мөн тус газрын бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2015 оны 414 дүгээр тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ээс нийт Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, 2015 оны 04 дүгээр сард шинэчлэн баталж, албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгосон.

2015 оны 11 сарын байдлаар тус газарт шинээр томилогдсон болон, Засгийн газрын 2003 оны "Төсвийн байгууллагын зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх тухай" 233 дугаар тогтоолын дагуу гэрээ байгуулан ажиллаж, гэрээгээр хүлээсэн үүргээ чанд сахин биелүүлсэн, төрийн албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцэн нөөцөд бүртгэгдсэн гэрээт ажилтнуудаас ажилд томилсон нийт 142 албан хаагчдад төрийн албаны болон бүртгэлийн байгууллагын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолт, байгууллагын үйлчилгээний стандарт зэргийг танилцуулж ажилласан.

Түүнчлэн тус газрын даргын тушаалаар томилогдсон төрийн албан хаагч бүрт ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг танилцуулж, мөрдүүлж, хэвших зорилгоор "Танилцах хуудас"-ыг бөглүүлэх ажлыг санаачлан ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор байгууллагын цахим хуудасны “Мэдээллийн ил тод байдал” буланд Улсын бүртгэлийн ерөнхий газрын удирдлагуудын иргэдийг хүлээж авч уулзах цагийн хуваарь, өргөдөл, гомдол хүлээн авах ажилтны овог нэр, өрөөний дугаар, утасны дугаар, хаяг, байршлын талаарх мэдээлэл байршуулж, мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.

Мөн байгууллагын цахим хуудаст УБЕГ-ын даргын 2009 оны 221 дүгээр тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн ерөнхий газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”, мөн газрын даргын 2009 оны 294 дүгээр тушаалаар батлагдсан Байгууллагын үйлчилгээний стандартыг тус тус байршуулсан болно.

*Үйл ажиллагааны зорилт:9. Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгуулага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах;*

Улсын бүртгэлийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ, хийх ажлыг “Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн”, “IRIM Монгол” төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж, уулзалт зохион байгуулсан боловч төсөв мөнгөний хүрэлцээгүй байдлын улмаас хэрэгжүүлээгүй болно.

*Үйл ажиллагааны зорилт:10. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх;*

Тус газрын даргын тушаалаар авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, Авлигатай тэмцэх газартай харилцан хамтран ажиллах эрх бүхий албан тушаалтныг 2012 оноос томилон ажиллуулж байна. Мөн нийслэлийн Улсын бүртгэлийн газар, 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нууцын ажил хариуцсан албан тушаалтныг Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах салбарын эрх бүхий албан тушаалтнаар томилон ажиллуулж байна. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх чиг үүргийг 2015 онд шинэчлэн баталсан ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусган, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Эрх бүхий албан тушаалтны өрөө тасалгаанд зориулалтын сейф байршуулж, байгууллагын албан хаагчдын хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг ханган ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд эрх бүхий албан тушаалтан нь Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад идэвхитэй хамрагдаж, дараах ажлыг үр дүнтэй хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Харьяа газар, хэлтсийн дарга нарт албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргуулан авах талаар заавар, зөвлөмж боловсруулан хүргүүлж, албан хаагчдад ХАСХОМ-ийг [www.meduuleg.iaac.mn](http://www.meduuleg.iaac.mn) цахим хуудсанд цахим хэлбэрээр бүртгүүлэх, цаасан хэлбэрээр хэвлэх талаар тухай бүр зааварчилгаа өгч мэдүүлгийг хуулийн хугацаанд авч байна.

Тус газрын төрийн захиргааны нийт 1020 албан хаагчдаас хөрөнгө орлогын

мэдүүлгийг цаасан хэлбэрээр гаргуулан авч, [www.meduuleg.iaac.mn](http://www.meduuleg.iaac.mn) цахим хуудсанд бүртгүүлэн, 2014 оны ХАСХОМ-ийн нэгдсэн тайланг гаргаж, Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу тус байгууллагад томилогдохоор нэр дэвшсэн 142 иргэн, албан хаагчдаас хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тухай бүр гаргуулан авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх арга хэмжээг авч ажилласан.

УБЕГ-ын даргын тушаалаар 2015 оны 11 сарын байдлаар шинээр нийтийн албанд томилогдсон 142 албан хаагч, хөрөнгө орлогод нь их хэмжээний өөрчлөлт орсон 23 албан хаагчдаас "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийг тухай бүр гаргуулан авч, цахим системд бүртгэн ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газраас 2015 оны 01-03 дугаар сард тус газрын албан хаагчдын ХАСХОМ-ийн бүрдүүлэлтэд хийсэн хяналт, шалгалтад УБЕГ-ын албан хаагчдын нэрсийн жагсаалт, цалингийн тодорхойлолтыг гаргаж, мэдүүлэг гаргагч албан хаагчдын 2012-2013 оны "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийг хуулбарлан өгч шалгуулав.

Нийслэлийн Улсын бүртгэлийн газар, 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нарт 2015 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн "Мэдүүлгийн бүрдүүлэлтийн тухай" 1/614 тоот албан бичгээр Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийн бүрдүүлэлтийг зохион байгуулж ажиллах талаар зөвлөмж, чиглэлийг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

*Үйл ажиллагааны зорилт:11. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх;*

"Улсын бүртгэлийн ажилтны ёс зүйн дүрэм"-ийг бүртгэлийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2014 оны 319 дүгээр тушаалаар батлан, байгууллагын цахим хуудсанд байршуулж, албан хаагчдад мөрдүүлэн ажиллаж байна. Ёс зүйн дүрмийг баталснаар албан хаагчдын сахилга хариуцлага дээшилж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой болсон.

Албан хаагчийн шударга байдал, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэхийн тулд албан хаагчдыг бүртгэлийн үйл ажиллагааны чиглэлээр болон ёс зүй, харилцаатай холбоотой бүсчилсэн, нэгдсэн, төрөлжсөн сургалтуудад үе шаттайгаар хамруулах ажлыг зохион байгуулж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын гаргасан ёс зүйн зөрчлийг хянан шалгах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг чанд сахиж, мөрдүүлэх чиг үүрэг бүхий Ёс зүйн хороог тус газрын даргын 2015 оны "Ёс зүйн хороог шинэчлэн байгуулах тухай" 975 дугаар тушаалаар 8 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан.



Түүнчлэн тус газрын даргын 2014 оны 319 дүгээр тушаалаар батлагдсан "Улсын бүртгэлийн ажилтны ёс зүйн дүрэм"-ийн 5.4-т "Орон нутагт аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын тушаалаар 3-5 гишүүний бүрэлдэхүүнтэй салбар ёс зүйн хороо ажиллана." гэж заасны дагуу 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст "Салбар ёс зүйн хороо" ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд тус газрын "Ёс зүйн хороо"-гоор 3 албан хаагчтай холбоотой асуудлаар 1 удаа хуралдаж, холбогдох албан хаагчид арга хэмжээ авч ажилласан бөгөөд тус газрын дэргэдэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь 6 удаа хуралдаж, ёс зүйн хорооноос оруулсан асуудлуудыг авч хэлэлцэн дүгнэлт гарган, төрийн албаны салбар зөвлөлд хандаж ирүүлсэн албан бичиг, өргөдөл хүсэлтэд хариу өгч ажилласан.

Мөн байгууллагын цахим хуудасны "Хүний нөөц" буланд "Ёс зүйн хороо" цэсийг шинээр вэб холбоос үүсгэж, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам, Улсын бүртгэлийн ажилтны ёс дүрэм, Ёс зүйн хорооны бүрэлдэхүүн, Ёс зүйн хорооны хурлын хэлэлцэх асуудал, дүгнэлт, мэдээ, мэдээлэл, салбар ёс зүйн хорооны гишүүдийн талаарх мэдээлэл, Ёс зүйн хорооны дарга, нарийн бичгийн даргатай харилцах утасны дугаар зэрэг мэдээллийг байршуулж, мэдээллийг тогтмол шинэчилэн ажиллаж байна.

*Үйл ажиллагааны зорилт:12. Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх;*

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зөвшөөрсөн давхар ажил эрхэлж болох ажлын жагсаалтыг нийт албан хаагчдад танилцуулсан.

Тус газрын хэмжээнд хуулиар зөвшөөрсөн ажил үйлчилгээг давхар эрхэлж байгаа албан хаагчдын судалгааг Тамгын газрын хүний нөөцөөс авч, албан хаагчдад давхар ажил эрхлэх тохиолдолд Тамгын газраас зөвшөөрөл авч ажиллах талаар зохих мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

*Үйл ажиллагааны зорилт:13. Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах;*

Иргэд болон бүртгэлийн ажилтныг хууль, эрх зүйн мэдээллээр хангахтай холбогдуулж тайлант хугацаанд байгууллагын цахим хуудаст шинээр УИХ-аар баталсан хууль 36, Засгийн газрын тогтоолоор баталсан 16 дүрэм, журам, хөтөлбөр, Хууль зүйн сайдын тушаалаар баталсан 13 журам, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан 38 журам, нийт 103 хууль, дүрэм журам, заавар шинэчлэн байршуулав. Үүнд:

УИХ-аас 2015 онд шинэчлэн баталсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хууль зүйн сайдын тушаалаар батлагдсан "Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам", "Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам", "Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам", "Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх, үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам", "Иргэний улсын бүртгэл хөтлөх журам", Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар "Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх журам", "Маягт, индекс, баталгааны тэмдгийн загварыг шинэчлэн

батлах тухай журам”, “Иргэний бүртгэл, мэдээллийн байгууллагаас үндэсний энгийн гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох технологи ажиллагааны журам”, Төрсний бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, бүртгэл хөтлөх журам зэрэг 2015 онд шинээр батлагдсан хууль тогтоомжийг шинэчлэн байршуулав.

Мөн Улсын бүртгэлийн үйлчилгээнд иргэдээс авч буй төлбөр, хураамжийн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудасны “Үйлчилгээ” буланд бүртгэлийн үйлчилгээний төрөл тус бүрээр гарган байршуулсан. Мөн мэдээллийг Улсын бүртгэлийн газар, хэлтсийн нэгж тус бүрийн үйлчилгээний танхимын мэдээллийн самбарт иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар байршуулан ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний мэдээллийн нээлттэй, ил тод, шуурхай байдлыг хангах зорилтын хүрээнд Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжийн хэрэгжилт бусад цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд, олон нийтэд цаг тухайд нь хүргэж, сурталчилан ажиллав.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжээс хүргэж эхэлсэн талаар болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, хуулийн этгээдийн онлайн үйлчилгээ, бусад цаг үе, үйл явдлын арга хэмжээг сурталчилах хүрээнд тайлант хугацаанд нийт 47 хэвлэл мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор 122 удаагийн сурталчилгааг телевиз, мэдээллийн цахим сайт, өдөр тутмын сониноор дамжуулан олон нийтэд хүргэхээс гадна телевиз, радиогийн нийт 17 нэвтрүүлэгт оролцсон байна. Тухайлбал:

- 01 дүгээр сарын 05-ны өдөр UBS телевиз, 01 дүгээр сарын 13-ны өдөр Монголын үндэсний олон нийтийн телевизийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт Эд хөрөнгийн бүртгэлийн газрын дарга Н.Туяа оролцож, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг сумаас иргэдэд үзүүлж эхэлсэн талаар;
- 3 дугаар сарын 12-ны өдөр HD Монгол телевизийн “Өглөө” хөтөлбөрийн “Зочны цаг” нэвтрүүлэг, 3 дугаар сарын 14-ний өдөр “Тодруулга” нэвтрүүлэгт, 3 дугаар сарын 20-ны өдөр Парламентийн суваг телевизийн “Хуулийн цаг” нэвтрүүлэг болон 3 дугаар сарын 28-ны өдөр Монголын радиогийн 20 минутын нэвтрүүлэг, 5 дугаар сарын 08-ны өдөр УИХ-ын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн албаны “Хуулийн цаг”-ийн тусгай нэвтрүүлэг, 5 дугаар сарын 25-ны өдөр ТВ-8 телевизийн бэлтгэсэн 40 минутын нэвтрүүлэгт Гадаадын хөрөнгө оруулалт, хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга Ш.Жолбарс оролцож, Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль болон онлайн бүртгэлийн талаар;
- 3 дугаар сарын 18-ны өдөр Ийгл телевизийн “Зочны цаг” нэвтрүүлэгт Тамгын газрын дарга С.Алтангэрэл оролцож, Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн, сургалтын талаар тус тус ярилцлага, мэдээлэл өгч ажиллав.
- Мөн Монголын FM-үүдийн холбоотой хамтран ажиллах хүрээнд 1, 2, 3 дугаар саруудад FM107.5 радиогийн “Бүртгэл ба хууль” 30 минутын ярилцлагын нэвтрүүлэгт холбогдох газрын дарга нарыг оролцож ажиллав.
- Шинээр батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг сурталчилах зорилгоор нийт 17 хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ,

ярилцлага өгч, холбогдох албан тушаалтан телевизийн 8 удаагийн нэвтрүүлэгт оролцов.

- Мөн УИХ-ын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн алба болон ТВ-8 телевизтэй хамтран Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль, онлайн үйлчилгээг сурталчилах ажлын хүрээнд тусгай нэвтрүүлэг бэлтгэж нийт 8 телевизээр цацуулсан болно. Нэвтрүүлгийн бичлэгийг байгууллагын цахим хуудас, ютүбд байршуулсан.
- 5 дугаар сарын 25-ны өдөр ТВ-8 телевизээс бэлтгэсэн “Цахим засаглал” сэдэвт 40 минутын нэвтрүүлэг болон 6 дугаар сарын 06-ний өдөр [www.erkhzui.mn](http://www.erkhzui.mn) хуулийн сайтад ярилцлага өгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон онлайн үйлчилгээг сурталчилла. Мөн уг ярилцлагыг [gogo.mn](http://gogo.mn), [24tsag.mn](http://24tsag.mn), [ikon.mn](http://ikon.mn), [zaluu.com](http://zaluu.com) сайтуудад тус тус байршуулав.

Мөн 2015 оны 9 дүгээр сарын 07-ноос 14-ны өдрүүдэд Нийслэлийн 6 дүүрэгт Хууль зүйн яам, түүний харъяа агентлаг байгууллагууд, нийслэлийн 6 дүүргийн Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулсан “Хууль тогтоомж сурталчилах нэгдсэн арга хэмжээ”-нд тус газрын нэгжүүд болон дүүргийн бүртгэлийн хэлтсүүдийн давхардсан тоогоор нийт 70 гаруй албан хаагч идэвхи санаачлагатай оролцож, нийт 12720 иргэнд үйлчилгээ, мэдээлэл зөвлөгөө өгч, гарын авлага тарааж ажилласан. Үүнд:

Арга хэмжээний үеэр Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, журам, зааврын талаар 5800 гаруй иргэнд эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Түүнчлэн үндсэн чиг үүргийн хууль тогтоомжуудаас гадна бүртгэлийн байгууллагын танилцуулга, үйл ажиллагаа, үйлчилгээний бичиг баримтын бүрдүүлэлт, үнэ хураамжийн талаарх гарын авлага, нэрийн хуудас, ном товхимол зэргийг бэлтгэж 4966 иргэнд тараасан болно.

Арга хэмжээний үеэр иргэдэд зарим төрлийн иргэний бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь хүргэж ажилласан. Тухайлбал:

- Иргэний цахим үнэмлэхээ гэж үрэгдүүлсэн, гэмтээж хүчинтэй байдал нь алдагдсан 978 иргэний цахим үнэмлэхийн захиалгыг ТҮЦ машины тусламжтайгаар хүлээн авч өдөрт нь хэвлэн иргэдэд буцааж олгов.
- Иргэний үнэмлэхийн хугацаа нь дууссан 42 иргэний материалыг хүлээн авч, зураг, хурууны хээгээр бүртгэн цахим үнэмлэхийн 25, 45 насны хугацааны сунгалтын үйлчилгээг үзүүлэв.
- Үндэсний энгийн гадаад паспортын хүчинтэй хугацаа нь дууссан 934 иргэний материалыг хүлээн авч тухайн өдрүүдэд өдөрт нь буцаан олгох ажлыг тус тус зохион байгуулсан.

Уг арга хэмжээг МҮОНРТВ, TV5, TV9, TM, EAGLE, C1, ZATV, TV1, KMG, Royal HDTV, Эх орон, Соёмбо телевиз, [shuud.mn](http://shuud.mn), [zaluu.com](http://zaluu.com), [news.mn](http://news.mn), [dorgio.mn](http://dorgio.mn), [montsame.mn](http://montsame.mn), [itoim.mn](http://itoim.mn), Монголын мэдээ, Үнэн сонин, Монголын радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, ярилцлага өгсөн болно.

Үйл ажиллагааны зорилт:14. Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах;

Иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг тус газрын цахим хуудас дахь Зочны дэвтэр, Онлайн лавлах 1800-1890 мессенжер, фэйсбүүк хаяг, Бүртгэлийн нэгдсэн лавлах утас 1800-1890, иргэнд ээлтэй утас 70122014, Засгийн газрын <https://zasag.mn> цахим хуудасны 11-11 мэдээллийн төв болон бичгээр тус тус хүлээн авч хуулийн хугацаанд зохих журмын дагуу шуурхай шийдвэрлэн хариу өгч ажиллаж байна.

2015 оны 10 сарын байдлаар Улсын бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 утсанд 55988 иргэн, [online.1890@yahoo.com](mailto:online.1890@yahoo.com) мессенжер хаягаар 843 иргэн холбогдож, <https://burtgel.gov.mn> цахим хуудас дахь Зочны дэвтэрт 194 иргэн санал, хүсэлт ирүүлснийг судлан үзэж тухай бүр холбогдох хариуг өгч ажилласан.

Шинэчлэлийн Засгийн газрын [www.zasag.mn](http://www.zasag.mn) цахим хуудас дахь 11-11 төвд тус байгууллагын албан хаагчид болон үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 363 иргэн хандсанаас санал хүсэлт 191, гомдол 137, шүүмжлэл 25, талархал 6, өргөдөл 4 тус тус байна. Дээрх санал, хүсэлт, гомдол, шүүмжлэлийг тухай бүр шийдвэрлэн ажиллалаа.

2015 оны 10 сарын байдлаар тус газарт иргэд байгууллагаас нийт 8809 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэнээс бичгээр 4752, 11-11 төвөөр 363, цахим хэлбэрээр 139, утсаар 985, биечлэн уулзсан 2568, бусад хэлбэрээр 2-г тус тус хүлээн авч, тухай бүр шийдвэрлэн, иргэдэд хариу өгч ажиллаж байна.

Тайлант хугацаанд тус газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн 2015 оны 01-07 дугаар сарын мэдээ болон 2015 оны 1, 2, 3 дугаар улирлын мэдээг цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүр байршуулж мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна.

Үйл ажиллагааны зорилт:15. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах;

Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр Улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах, үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлын хүрээнд тайлангийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль шинэчилсэн найруулгаар батлагдаж, энэ оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан байгууллагын <https://burtgel.gov.mn/> цахим хуудас, хуулийн этгээдийн цахим бүртгэлийн програм хангамжийг ашиглан иргэдэд хуулийн этгээдийн нэр шалгах, онлайнгаар илгээж, захиалах, баталгаажуулах, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах үйлчилгээг тус тус үзүүлж байна. Хуулийн этгээдийн цахим бүртгэлийн үйлчилгээ үзүүлж эхэлснээс хойш 3000 гаруй хүсэлтийг хүлээн авч бүртгэлийн үйлчилгээг үзүүлээд байна.

Хуулийн этгээдийн бүртгэлийг ажлын 2 өдөр /гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж ажлын 10 өдөр/-ийн дотор хийж, цахим гэрчилгээг өргөдөл гаргагчид цахим хэлбэрээр илгээх, хүссэн үедээ хэвлэх боломжтой болсон.

- Төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машинаар улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх:

Төрийн үйлчилгээний цахим машин буюу ТҮЦ машинаар иргэний бүртгэлийн 6 төрлийн лавлагаа, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн түүхчилсэн лавлагаа, хуулийн этгээдийн бүртгэлийн дэлгэрэнгүй болон хуулийн этгээд бүртгэлгүй тухай лавлагаа олгох, хаяж гээгдүүлсэн, хүчинтэй байдлыг алдагдуулсан иргэний үнэмлэх дахин авах хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах гэсэн нийт 10 төрлийн лавлагаа, үйлчилгээг үзүүлж байна.

2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар ТҮЦ машинаар 787594 иргэний улсын бүртгэлийн лавлагаа, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 56918 лавлагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 6054 лавлагааг иргэдэд олгож, иргэний үнэмлэх дахин авах 23370 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

- Улсын бүртгэлийн байгууллагаас олгох баримт бичгийг шуудангийн сүлжээгээр дамжуулан “Гараас гарт хүргэх” үйлчилгээ:

“Монгол шуудан” ТӨХК-тай хамтран хэрэгжүүлж буй “Гараас гарт хүргэх” шуудангийн үйлчилгээг өргөжүүлж, Монгол Улсын Үндэсний энгийн гадаад паспортоос гадна Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, холбогдох баримт бичгийг шуудангийн сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэдэг болсон.

Мөн уг үйлчилгээгээр 2015 оны 07 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн орон нутгийн гадаад паспортыг, 2015 оны 08 дугаар сарын 03-ны өдрөөс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн бүртгэгдсэн гэрчилгээ, лавлагааг “Монгол шуудан” ТӨХК-ийн хүргэлтийн үйлчилгээгээр хүргүүлэх ажлыг тус тус эхлүүлэн ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд нийт 10695 иргэний гадаад паспорт, 830 хуулийн этгээдийн гэрчилгээ, дүрэм, холбогдох баримт бичгийг иргэн, хуулийн этгээдийн хаягаар шуудангаар хүргээд байна.

- Хүн амын төвлөрөл ихтэй сумдад эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх:

Хүн амын төвлөрөл ихтэй Сэлэнгэ аймгийн Мандал бүс /Мандал, Баянгол сум/, Сайхан бүс /Сайхан, Сант, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сум/, Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Өмнөговь аймгийн Даланзадгад сумдад эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн ePRS системийг нэвтрүүлэн, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг үзүүлж байна. Өвөрхангай аймгийн Хархорин, Төв аймгийн Лүн суманд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн ePRS системийг нэвтрүүлэх шилэн кабелийн холболт хийгдэж, техникийн дэд бүтцийн бэлтгэл ажлыг хийж байна.

Бусад сумын иргэдэд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сумын улсын бүртгэгч нар эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдүүлэг, нотлох баримтыг суманд хүлээн авах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж, эхний 9 сарын байдлаар нийт 11207 мэдүүлгийг суманд хүлээн авсан байна.

- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг түргэн хугацаанд хийх:

Тус газрын даргаас холбогдох нэгжүүдэд чиглэл хүргүүлсний дагуу эд хөрөнгийн эрхийн анхны бүртгэлийг 14 хоногийн дотор бүртгэдэг байсныг ажлын 5 хоногийн дотор, эд хөрөнгө өмчлөх эрх гэрээ, хэлцлийн үндсэн дээр шилжсэнийг 7 хоногийн дотор бүртгэдэг байсныг ажлын 3 хоногийн дотор, яаралтай үйлчилгээний хөлс төлсөн барьцааны гэрээг ажлын 8 цагийн дотор бүртгэдэг байсныг ажлын 4 цагийн дотор тус тус улсын бүртгэлд бүртгэж байна.

- Хорооноос үзүүлж буй улсын бүртгэлийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, УБЕГ-ын даргын хооронд 2014 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, энэхүү санамж бичгийн хүрээнд иргэний бүртгэлийн онлайн сүлжээнд нийт 89 хороог холбож, холбогдох тохиргоог хийн, шилжилт хөдөлгөөний, гэрлэсний, гэрлэлт цуцалсны /шүүхийн журмаар/, гэрлэлт сэргээсний, төрсний болон гэрлэлтийн гэрчилгээ дахин олголтын, иргэний үнэмлэхийн, оршин суугаа хаягийн лавлагаа олгох зэрэг үйлчилгээг хорооны түвшинд үзүүлж байна.

Хурууны хээ болон цахим иргэний үнэмлэх ашиглан бүх аймаг, дүүрэг, онлайн сүлжээнд холбогдсон хороодоос иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн 10 төрлийн лавлагаа олгох системийг нэвтрүүлэн, ашиглаж эхлээд байна.

- Гадаад паспортын мэдүүлгийн хуудсыг програмаас хэвлэх:

Үндэсний энгийн гадаад паспорт шинээр захиалах хүсэлт гаргаж буй иргэн бүртгэлийн байгууллагад ирж олон асуулт бүхий мэдүүлгийн хуудсыг бөглөдөг байсныг өөрчилж иргэний хурууны хээний бүртгэлийг уншуулж, тухайн иргэний анкетийг хэвлүүлэн иргэнээр уншуулж хянуулан, гарын үсэг зуруулах үйлчилгээг нэвтрүүлсэн. Ингэснээр иргэд цаг алдалгүй үйлчилгээ авах бололцоо бүрдсэн.

- Хүн амын төвлөрөл, ажлын ачаалал ихтэй нэгжийн орон тоог нэмэгдүүлэх:

Тус газрын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан тус газрын 2015 оны "Албан тушаалын орон тоо, ангилал, зэрэглэл батлах тухай" 387 дугаар тушаалаар нийслэлийн Улсын бүртгэлийн газар, дүүргийн Бүртгэлийн хэлтсийн орон тоог баталсан. Уг тушаалаар хүн амын төвлөрөл, ажлын ачаалал ихтэй Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Бүртгэлийн хэлтсүүдэд улсын бүртгэгч нарын орон тоог, Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн Бүртгэлийн хэлтсүүдэд хяналтын улсын байцаагчийн орон тоог ачаалал багатай нэгжээс шилжүүлэх байдлаар тус тус нэмэгдүүлсэн.

- Байгууллагын үйл ажиллагааг түргэн шуурхай болгох:

Байгууллагын мэдээлэл солилцооны хурдыг нэмэгдүүлэх, шуудан, бичиг хэргийн зардлыг бууруулах зорилгоор байгууллагын үйл ажиллагаанд e-Office системийг нэвтрүүлэх тухай УБЕГ-ын даргын тушаалаар дотоод сүлжээнд хэрэглэх боломжийг бүрдүүлсэн e-Office системийг УБЕГ, НУБГ, 21 аймаг, 9 дүүргийн нийт 864 хэрэглэгчийг хамруулан ашиглалтанд оруулж ашиглаж хэвшээд байна.

Мөн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нэг ажлын байран дээр 5-аас дээш жил ажилласан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 16 улсын бүртгэгчийг ажлын байранд шилжүүлэн ажиллуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Авлига, хүнд суртал болон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй бүртгэлийн байгууллагын ажлын байр, албан тушаалыг тодорхойлох судалгааны ажлыг төрийн бус байгууллагаар хийлгэхээр судлан ажиллаж байна.

Үйл ажиллагааны зорилт:16. Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу тус байгууллагын байранд аж ахуйн нэгж, байгууллага байрлахгүй байгаа болно.

*Үйл ажиллагааны зорилт:17. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх;*

2015 оны 11 сарын 13-ны өдрийн байдлаар тус газрын албан хаагчдаас албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, ёс зүйн болон сахилгын зөрчил гаргасан үндэслэлээр нийт 78 тушаалаар 118 албан хаагчдад Төрийн албаны тухай хууль болон, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Улсын бүртгэлийн ажилтны ёс зүйн дүрэм, тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу сахилгын шийтгэл ногдуулсан байна.

АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын хэрэгжилтийг хангах хүрээнд албан хаагчдад ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт байршуулан нийтэд мэдээлж байна.

Иргэдэд үзүүлж буй үйлчилгээний шат дамжлагыг багасгах, үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх зорилгоор улсын бүртгэлийн холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг ажлыг хийж байна.

Энэ хүрээнд Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 2014 онд Хууль зүйн яаманд хүргүүлсэн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийг Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлж, чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг хийгдсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас 2015 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр баталж, 03 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар үйлчилгээний шат дамжлагыг багасгах, хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, улсын бүртгэлийн гэрчилгээг цахим болгох зэрэг төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгож, иргэдэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой болсон.

Өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулиар хуулийн этгээдийг шинээр байгуулан, улсын бүртгэлд бүртгүүлэхэд 12 төрлийн бичиг баримт бүрдүүлж, 8 шат дамжлагаар, 5 хоног шаардагддаг байсан бол хууль шинэчлэн батлагдсанаар бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээд нь бүртгэлийн байгууллагад биеэр ирж, дараалалд зогсолгүйгээр орон зай, цаг хугацаанаас үл хамааран онлайн хэлбэрээр үзүүлэх, цахимжсан баримтад үндэслэн бүртгэл хийх, улсын бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай мэдээллийг байгууллагын вэб сайтад хандан саадгүй авах, хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд 6 төрлийн бичиг баримт бүрдүүлж, 3 шат дамжлагаар, 1-2 хоногийн дотор бүртгүүлэх боломжтой болсон.

Хуулийн этгээдийн цахим бүртгэлийн үйлчилгээ үзүүлж эхэлснээс хойш 2015 оны эхний 9 сарын байдлаар 3000 гаруй хүсэлтийг хүлээн авч бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Тайлангийн хугацаанд тус байгууллагад АТГ-аас зөрчил арилгуулах, хариуцлага тооцож арга хэмжээ авахуулах зөвлөмж, чиглэл, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах мэдэгдэл ирүүлээгүй болно.

**Хоёр. Авлигатай тэмцэх санал, санаачилга гаргах хүрээнд:**

Үйл ажиллагааны зорилт:18. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх;

Тус газрын албан ёсны цахим хуудас <https://burtgel.gov.mn> болон мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах буланг ажиллуулж, мэдээллийг тогтмол шинэчилж хэвшсэн.

Уг ажлын хүрээнд иргэд тус газрын үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх бүх мэдээллийг энгийн ойлгомжтой, хүртээмжтэй шуурхай байдлаар хүргэх, зайлшгүй шаардлагатай үйлчилгээний баримт бичгийн бүрдүүлэлтийн жагсаалт, маягыг татаж авах, хайлт хийх зэрэг хэрэгтэй мэдээллээ энгийн хялбар аргаар үзэх, ашиглах боломжийг бий болгож өгсөн.

Тус газрын 2015 оны "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулж, ерөнхий газрын даргаар батлуулан, Авлигатай тэмцэх газар болон нийслэлийн Улсын бүртгэлийн газар, 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс болон бусад газар, хэлтэст хүргүүлэн, төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Мөн тус газрын 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан, 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудаст байршуулж олон нийтэд мэдээлж байна.

Улсын бүртгэлийн байгууллагын салбар нэгжийн авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээг 2015 оны 3 дугаар улиралд хийж гүйцэтгэв.

Үйл ажиллагааны зорилт:19. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт;

Байгууллагын нийт албан хаагчдын хурал, удирдах ажилтны зөвлөгөөн, газар, хэлтсийн хурал, сургалт, семинар дээр ерөнхий газрын дарга, газар, хэлтсийн удирдлагууд улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хүргэх, үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах, үйлчилгээний шат дамжлагыг бууруулах санал санаачилга гаргаж, авлигаас урьдчилан сэргийлэх талаар тогтмол мэдээлэл хийн ажиллаж байна.

Байгууллагын удирдлага нийт албан хаагчдад авлигыг үл тэвчих, ёс зүйтэй байх, шударга ёсыг эрхэмлэн ажиллах талаар үүрэг чиглэлийг тухай бүр өгч ажиллаж байна.



Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах талаар чиглэл боловсруулж, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс болон ерөнхий газрын газар хэлтсийн дарга нарт 2015 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 2/10944 тоот албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилгад нэгдэн хамтран ажиллаж байна.

Энэ хүрээнд Улсын бүртгэлийн үйлчилгээ, үйл ажиллагаа, ашиг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хүйсийн тэгш эрхийн төв болон БНСУ-ын Кокун төвтэй хамтран Солонгос улсын иргэдтэй гэр бүл болох гэж байгаа эмэгтэйчүүдэд, Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвтэй хамтран Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагч, Сэргээн засалт, Хөгжлийн Үндэсний төвийн 30 гаруй албан хаагчдад сургалтыг зохион байгуулсан байна. Мөн "Монголын телевизүүдийн холбоо" төрийн бус байгууллагатай хамтран Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан хялбаршуулсан буюу онлайн бүртгэлээр сурталчилгаа хийв.

Түүнчлэн Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой баримт бичиг бүрдүүлэх үйлчилгээг шуурхай хийж өгнө гэж иргэдээс бэлэн мөнгө авдаг иргэдийн зураг мэдээллийг тус газрын үйлчилгээний зааланд "Мэдээллийн самбар"-т байршуулж, цагдаагийн хэсэгтэй хамтран ажиллаж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевизээр анхааруулсан мэдээлэл өгч ажиллаж байна.

Улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн сэтгэл ханамжийг судалж, үйлчилгээнд гарч буй алдаа дутагдлыг илрүүлж, дүн шинжилгээ хийн үйл ажиллагааг цаашид сайжруулах үүднээс Нийслэлийн 6 дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын 1, 2, 3-р байрны бүртгэлийн үйлчилгээний танхимаар үйлчлүүлсэн иргэдийг хамруулсан санал асуулгыг 2015 оны 1 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Судалгаанд дээрх танхимуудаар үйлчлүүлсэн 386 иргэд хамрагдсан. Судалгааны үр дүнд байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээг авах, бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх /вэб сайт болон мэдээллийн самбарын мэдээллийг тогтмол шинэчилж байх гэх мэт/, иргэдэд зөвлөгөө өгөх, угтах үйлчилгээг нэвтрүүлэх, үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлд анхаарах, үйлчилгээний албан хаагчдад зориулсан харьцааны соёл дээшлүүлэх сургалтыг тогтмол явуулах, үйлчилгээний танхимын ая тухтай орчинг бий болгох, бүртгэлийн хэлтсүүд дотоод зохион байгуулалтаа зөв хийж, дарааллыг зохистой шийдвэрлэх зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байгаа талаар дүгнэлт хийж, гарсан алдаа дутагдлыг арилгах хүрээнд үйлчилгээний мэдээ мэдээллийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах, үйлчилгээний албан хаагчдад сургалт явуулах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.

Албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилах, соён гэгээрүүлэх болон иргэдэд үзүүлж буй бүртгэлийн үйлчилгээний мэдээллийг нээлттэй хүргэхэд байгууллагын төсвөөс тодорхой хөрөнгө зарцуулан ажиллаж байна.

Үйл ажиллагааны зорилт:20. Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх;

Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын тасралтгүй сургалтын нэгдсэн хөтөлбөр, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд сургалт, семинар зохион байгуулах замаар албан хаагчдын мэдлэг чадавхийг дээшлүүлж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, албан хаагчдын шударга байдал, түүнийг нэмэгдүүлэх зорилгоор 2015 оны 3 дугаар улирлын байдлаар 35 сургалт, семинар зохион байгуулж, давхардсан тоогоор 1114 албан хаагчийг хамруулан ажиллав. Тухайлбал,

- *Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны нэгдсэн сургалт, семинар*

2014 онд хийж гүйцэтгэсэн ажлаа дүгнэж, цаашид хийж гүйцэтгэх ажлаа төлөвлөх, төрийн үйлчилгээг сайжруулахад цаашид авч хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны талаар орон нутгийн удирдлагыг мэргэжлийн арга зүйгээр хангах, зөвлөлдөх зорилгоор зохион байгуулдаг бүртгэлийн байгууллагын Удирдах ажилтны нэгдсэн сургалт, семинарыг 2015 оны 03 сарын 18-ны өдрөөс 20-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Уг сургалтаар “Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, чиглэл” сэдвээр Тамгын газрын ахлах мэргэжилтэн Ө.Өлзийбаасан, Хүний эрхийн төв комиссын референт Б.Болорсайхан “Хүний эрхэд суурилсан хандлага” сэдвээр илтгэл, хичээл зааж, Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны ажилтан Д.Жаргалан, урьдчилан сэргийлэх хэлтсийн комиссар Т.Дэлгэрбаяр нар “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр тус тус мэдээлэл өглөө.

- *Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарын сургалт*

“Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга, уг хуулийг дагаж мөрдөх журмыг улсын бүртгэгч нарт сурталчилан таниулах сургалт, семинарыг 2015 оны 3 дугаар сарын 06-ны өдрөөс 07-ны өдрүүдэд Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд зохион байгуулсан. Энэхүү сургалт семинарт 21 аймаг болон Багануур дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүртгэлийн хяналтын улсын байцаагч, хуулийн этгээдийн улсын бүртгэгч зэрэг нийт 57 албан хаагч хамрагдсан.

Улсын бүртгэгч нар шинээр батлагдан гарсан хууль, холбогдох дүрэм, журмын талаар шаардлагатай мэдээ мэдээлэл авч, тогтсон нэг ойлголтод хүрч чадсан сургалт болсон гэж үнэлсэн ба оролцсон нийт албан хаагчдад хууль тогтоомжийн гарын авлага бэлтгэн хүргэв.

- *Эд хөрөнгийн эрхийн бүртгэгч нарын сургалт*

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч нарт зориулсан ахисан түвшний сургалтыг дараах байдлаар зохион байгууллаа. Үүнд:

Нотариатчдын танхимтай хамтран 4 дүгээр сарын 7–ны өдөр эд хөрөнгийн эрхийн бүртгэгч, нотариатын хамтарсан зөвлөгөөн зохион байгуулж, 25 албан хаагч, 15 нотариатч хамрагдлаа.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газартай хамтран 4 дүгээр сарын 23-ны өдөр Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын хурлын танхимд сургалт зохион байгуулж, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 45 албан хаагчийг хамрууллаа.

- *Иргэдэд зориулсан эрх зүйн сургалт*

Улсын бүртгэлийн үйлчилгээ, үйл ажиллагаа, бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчилах зорилгоор иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай үндсэн ойлголт, төрлүүд, анхаарах асуудлын талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрх зүйн ойлголт өгөх, тэдэнд бүртгэлийн үйлчилгээг хүргэх нөхцөл боломжоор хангахад чиглэгдсэн сургалтыг Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвд 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулав.

Сургалтад Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагч, Сэргээн засалт, Хөгжлийн Үндэсний төвийн 30 гаруй албан хаагч хамрагдсан.

- *Орон нутгийн бүсчилсэн сургалт*

Хөвсгөл, Баян-Өлгий, Орхон, Дорноговь аймгуудад бүсийн сургалт зохион байгуулж, 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нийт 310 албан хаагчийг хамруулав. Уг сургалтаар “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр хичээл заав.

Мөн байгууллагын үйлчилгээний стандарт, улсын бүртгэгчийн ёс зүйн чиглэлийн хичээлийг зохион байгуулж буй сургалт бүрийн хөтөлбөрт тусган ажиллаж байна.

УБЕГ-ын нийт албан хаагчдаас сургалтын хэрэгцээ шаардлага тодорхойлсон судалгаа авсны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдах хүсэлт гаргасан нийт 32 албан хаагчдыг 2015 оны 03 дугаар сарын 31-ний өдөр сургалтад хамруулав. Мөн “Хуурамч бичиг баримтаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг Хууль сахиулахын их сургуультай хамтран 2015 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан.

2015 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан анхан шатны удирдах ажилтны сургалтад “Албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх, шударга ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр АТГ-ын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар Б.Туул хичээл заав.

Мөн 2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс, сургагч багш Ү.Амарбат нартай хамтран “Шударга Монгол хүний 7 дадал” сэдвээр сургалт зохион байгуулж, үйлчилгээний 25 албан хаагчийг хамруулав.

Сургалт, семинар нь онолын мэдлэг олж авахаас гадна, бүртгэл хийхэд гарч буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэж, нэгдсэн нэг ойлголтод хүрсэн ач холбогдолтой болсон.

Тус байгууллагын нийт албан хаагчдаас “Авлигад өртөхгүй байх амлалт”-ыг авах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Ерөнхий газрын дотоод нэгжүүд болон 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдаас “Авлигад өртөхгүй байх амлалт”-ыг авах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав.

Тус газар нь дотоод аудит болон бүртгэлийн хяналтын чиглэлээр 2015 оны үйл ажиллагааг төлөвлөн хяналт шалгалтын ажлыг тогтмол хийн ажиллаж байна.

Бүртгэлийн зөрчлийг шийдвэрлэх зорилгоор хяналтын улсын байцаагчийн нийт 113 дүгнэлт үйлдэж, төв, орон нутгийн хяналтын улсын байцаагч нарын 698 дүгнэлтийг цахим санд хянан баталгаажуулж, нийт 1597 зөрчил илрүүлсний 46.3 хувь нь иргэнийн бүртгэлийн, 7.3 хувь нь хуулийн этгээдийн бүртгэлийн, 37.8 хувь нь эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн, 10.2 хувь нь гадаад паспорт олгох үйл ажиллагаанд тус тус гарсныг залруулж ажиллав.

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5.1 дэх заалтыг мөрдлөг болгон 111 иргэний гадаадад зорчих эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлж, 429 иргэний гадаадад зорчих эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлснийг сэргээсэн байна. Үүнээс прокурорын зөвшөөрөл бүхий хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу 47 иргэний, гадаад паспорт авах зорилгоор бусдад баримт бичгээ ашиглуулсан, ашигласан, авахыг завдсан 64 иргэний гадаадад зорчих эрхийг хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр тус тус түр хугацаагаар түдгэлзүүлж, мөн хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу 249 иргэний, хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр 180 иргэний гадаадад зорчих эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлснийг тус тус цуцалсан байна.

Бүртгэлийн хяналтын газраас Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар, Багахангай, Сонгинохайрхан дүүргийн бүртгэлийн хэлтэс болон Завхан, Ховд, Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн шалгалт, 2015 оны төлөвлөгөөт шалгалтыг Архангай, Булган, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хийж, шалгалтын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилган ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Багануур, Багахангай, Налайх дүүрэгт нийт 12 удаагийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр дотоод хяналт шалгалт хийв. Түүнчлэн Баянхонгор аймаг, Сэлэнгэ аймгийн Мандал Сум, Завхан аймгийн Тосонцэнгэл сум болон Нийслэлийн Багануур, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн бүртгэлийн хэлтсийн 2015 оны 1 дүгээр улиралд боловсруулсан эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 512 мэдүүлгийг түүвэрчлэн авч шалгасан.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, ажил сайжруулах талаар ерөнхий газрын даргын албан даалгавар, хяналтын улсын байцаагчийн албан шаардлага боловсруулж, хүргүүлэн ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд тус байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд авлигын шинжтэй буюу ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудал илрээгүй байна.

## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР